



Г АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮН КОМИССАР  
З.ДАШДАВАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatrural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.07.16 № 02

Г Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх  
үйл ажиллагааны талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

Авлигатай тэмцэх газрын авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн дараах ажлын тоо, мэдээллийг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар бэлтгэн хуулийн хугацаанд ирүүлнэ үү. Үүнд:

1.Хүлээн авсан, хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл буюу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээсэн, хэрэг нээхээс татгалзсан, харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн тоо, мэдээлэл;

2.Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан буюу авлигын гэм хэрэгт явуулсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт буюу шүүхэд шилжүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, харьяаллын дагуу прокурорт шилжүүлсэн, түдгэлзүүлсэн хэрэг;

3.Авлигын гэмт хэрэгт холбогдуулан шалгасан нийтийн албан тушаалтан, түүнээс төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдэд хамаарах хэсгийг тусад нь бодит тоо, мэдээлэл зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

О.АЛТАНГЭРЭЛ



2024.07.16